

## АРВАН ФИЛОСОФИЧИЙГ НЭРЛЭЭЧ

*С.Бүжигнлхам, Этвөш Лорандын Их Сургуулийн докторант  
Э.Янжинлхам, магистрант  
МУИС, Философи шаашин судлалын тэнхим*

*Түлхүүр үг: боловсрол, ягшмал үзэл, тогтсон хандлага, хүйс, жендер, төлөөлөл*

“Philosophy of our times” хэмээх салбар бүрийн эрдэмтэд, чиглэл бүрийн философичдийн мэтгэлцээнийг толилуулдаг подкастын “Эрчүүд хийгээд бүсгүйчүүд хэрхэн боддог вэ?” гэх дугаарт оролцсон Британийн нейробиологич Жина Риппон XXI зуун гарчихаад байхад бид аливаа асуулт асуухдаа “эрэгтэй хүний тархи, эмэгтэй хүний тархи” хэмээн онцолж, хүйсээр ялган асуух аль XVIII зууны хандлагаасаа өдийг хүртэл салаагүй байгаа нь харамсалтай хэмээн шогширж яриагаа эхлүүлж билээ. Хүйсийн асуудлыг тойрон эргэлдэх хэвшмэл үзлийн занал (stereotype threat), далд өрөөсгөл хандлага (implicit bias), угтал бодол (prejudice), ялгаврлал (discrimination) байсаар байгаа тул бид ийнхүү онцолж ярих хэрэгцээ, шаардлага гарсаар буйг шүүмжилсэн Жинатай санал нийлэхгүй байхын аргагүй. Тархи судлаачид хүртэл тархийг эр, эм тархи хэмээн ялгаж судлах эсэхэд эргэлзэж (Xin, et al. 2019) эхэлсээр байтал, яагаад эмэгтэйчүүд эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллаж, амьдарч, нийгэмдээ хувь нэмрээ оруулсаар атал бид “хүүхнүүд” хэмээн ялгаж асууж, онцолж судалж, үе үе сануулж, нэг алхсан замаараа дахин дахин алхахгүй л бол жендертэй холбогдох аливаа ахиц бүр нэг урагш, хоёр хойш гэсэн хэмнэлтэй байсаар байгаа юм бол? Хэсэг бүлэг хүн болохгүй байгаад биш, эсвэл өөр нэг бүлэг хүн нь илүү онцгой байгаад биш, тогтолцоогоороо, уламжлалаараа, тогтсон хандлагын хүрээндээ жендерийн

асуудал амь бөхтэй оршиж, зүсээ хувирган, зүгээ өөрчилсөөр байгаа тул гарч буй ахиц бүрийг тэмдэглэх, онцлох, шинэ шинэ асуудал, өнцөгт соргог байх шаардлага байсаар байна. Ийнхүү жендерт хамаарах хэвшмэл үзэл бүтцийн хүрээнд бат бөх оршсоор байна гэдэг ерөнхийлсөн ажиглалтаа багтаамжийн хувьд багасгаж, философи судалж буй хүмүүс гэх олонлогт мөн ижил хүчин төгөлдөр байна уу гэдгийг бид уг судалгаагаар түншсэн болно. STEM талбартай адил “цөөхөн бүсгүйчүүдтэй” гэдгээрээ алдартай тул философи талбарыг онцолж сонгож, уг талбарт бүсгүйчүүд цөөн “байдгийн” шалтгаан, энэ байдал хэрхэн өөрчлөгдөж байгаа, гарч буй ахиц, тулгарч буй бэрхшээл зэргийн талаар уг өгүүлэлд ерөнхийлөн тоймлов.

Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн талбарт эрчүүд хүмүүнлэгийн талбарт бүсгүйчүүд давамгайл байгаа тухай үе үеийн тоон мэдээлэл дурдсаар ирсэн. Тухайлбал 2021 оны байдлаар АНУ-д хүмүүнлэгийн талбарын профессоруудын<sup>1</sup> 54,7% нь эмэгтэй, 45,3% нь эрэгтэй байсан бол шинжлэх ухааны талбарын профессоруудын 71,75% нь эрэгтэй, 28,25% нь эмэгтэй байсан байна (Zipria The Career Expert 2021). Гэтэл хачирхалтай нь дээрх тоо ёсоор “хүүхнүүд” давамгайл байх учиртай хүмүүнлэгийн талбар дундаас философи “эрчүүдийнх” гэдгээрээ алдартай. Доорх хүснэгтээс харахад байнгын албан тушаал эсвэл профессорын

<sup>1</sup> Эдгээр тоо мэдээнд байнгын албан тушаалд ажиллаж буй профессоруудыг онцолсон болно.

албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь 20-30% -ийн хооронд хэлбэлзэж байна. Энэ нь STEM талбарынхантай тун ойролцоо үзүүлэлт юм.

бус уг загварыг сонгов. Тэд уламжлалт өгүүлэгч, сонсогч гэх субъектуудыг функцийн томъёоллоор солихдоо ёс зүйн онолоос санаа аван прагматик оролт (өгүүлэгч), гаралт (сонсогч) хэмээх

Он	Улс	Албан тушаал	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Эх сурвалж
2021	АНУ	Философийн профессор (professor)	20,43%	(Zippia The Career Expert 2021)
2021	Их Британи	Философийн багш нар (permanent staff)	30%	(Beebee and Saul, Women in Philosophy in UK 2021)
2020	Герман хэлтэй орнууд	Философийн профессор (full time professor)	28%	(Klonschinski and Kraft 2022)
2018	Грек	Философийн багш нар (faculty members)	29%	(Illiadi, Theologou, and Stelios, 2018)

(Хүснэгт 1)

Тоон баримт төдийгүй уг талбарт ажиллаж буй хүмүүсийн үзэл хандлага ч цочирдом байх нь бий. Жишээлбэл хорь хүрэхгүй жилийн өмнө 2004 онд дэлхийн философийн өдрөөр, Ренминий их сургууль дээр зохион байгуулсан “Эмэгтэйчүүд ба философи” гэх сэдэвт симпозиумын үеэр Хятадын философич Зоу Гуопин(Zhou Guoping 周國平) “Яагаад хүүхнүүд философитой зууралдах ёсгүй вэ” гэх сэдэвтэй, бүсгүйчүүд логиктоо муу тул, нэмээд философи үзээд амьдралын гүнд нэвтрээд зовж шаналаад эмэгтэйлэг гоо сайхнаа алдчих болохоор зүглээд ч хэрэггүй гэсэн санаатай илтгэл тавьж байжээ (Pang-White 2022). Зоу Гуопиний уг “илэрхийллийг(utterance)” Квилл Кукла (Ребекка Кукла нэрээр боловсруулсан) хийгээд Марк Ланц нарын нийгмийн хэм хэмжээнд тулгуурласан хэлэх үйлдлийн онолын загварын хүрээнд тайлбарлая. Тэд хэлэх үйлдлийг тодорхойлохдоо “харилцааны бүтэцлэгдсэн систем доторх норматив функц бүхий үйлдэл” хэмээн өргөн утгаар тодорхойлохын хамт хэлэх үйлдлийг функцийн утгаар авч үзсэн байдаг (Kukla and Lance, ‘Yo!’ and ‘Lo!’ The pragmatic topography of the space of reasons. 2009, 2) тул онцлон сонгодог загвар болох Остины конвенци эсвэл Грайсын онолоос үүдэлтэй зорилтод(intention) тулгуурласан хэлэх үйлдлийн онолыг

ойлголтыг дэвшүүлсэн байдаг. Хэлэх үйлдлийн оролтонд нөхцөл байдлын хязгаар, өгүүлэгч болон сонсогчийн харилцаатай холбогдох хязгаар, хэд хэдэн конвенцийн биелэл зэрэг биелэвэл зохистой нөхцлүүд багтдаг. Жишээлбэл цэрэг, даргын харилцааг бодвоос цэрэг даргадаа тушаал өгч чадахгүй байх тэр нөхцөл нь оролтонд багтана. Хэлэх үйлдлийн “гаралт” нь тухайн үйлдлийн босгож буй норматив статус агаад энэ нь иллокутив үр нөлөөтэй уялдаатай байдаг. (R. Kukla 2014, 3) Хэлэх үйлдлийн онолын үүднээс харавал Зоу Гуопин “ёстой, ёсгүй” гэх утгаар эмэгтэйчүүд философидох хэрэггүй хэмээн илтгэсэн тул уг хэлэх үйлдлийг зааварчлал хэмээн харж болохуйц хэлзүйн бүтэцтэй байгаа юм. Зааварчлал нь “үнэнийг нотолж буй нотолгооны(truth claims)” нэг төрөл агаад, зарим үйлдэгчийн деонтик статусын тухай үнэн санааг тодорхой өгүүлэх үед хэрэглэж тухайн үйлдэгчдийн үйлдлийг зааварчилдаг аж. Гэтэл өнгөн бүтцийн хэл зүй тэр бүр найдвартай бишийн дээр “холбиромтгой”-г бодолцвоос Зоу Гуопиний илэрхийлэл “үнэний нотолгоо” бишийн дээр “зааварчлал” ч биш байгаа юм. Харин өгүүлэгчийн итгэл үнэмшлийг илэрхийлж буй “илэрхийлэл(expressive)” байна. Энэ нь ерөнхийдөө танин мэдэхүйн үр дүн авчирдаггүй агаад тэвчиж эсвэл үл тоон өнгөрч болдог хэлэх үйлдэл юм. Гэтэл Зоу Гоупиний илтгэлийн өнгөн бүтцийг

харан(need to, should not) зааварчлал эсвэл хурал дээр тавьж буй илтгэл тул батлал(assertive) гэж андуурч болохуйц байгаа нь тун хортой юм. Өөрөөр хэлбэл сонсогч хэн нэгний итгэл үнэмшил биш харин “бодит байдлыг” өгүүлж байна хэмээн алдаатай хүлээн авч(uptake) мэднэ. Марилин Фрейдманы хэлсэнчлэн “философи цөөхөн хэдий ч ахин дахин уншигдсаар байдаг эх зохиолуудтай тул түүхэн чухал эдгээр (эрэгтэй) сэтгэгчдийн мисожинист хандлага өнөөдөр ч амь бөхтэй оршоор байна (Friedman 2013, 24)” гэдэг санааг бодвоос “оролт”-д аль хэдийн энэхүү мисожинист конвенци байгаа гэж үзэж болох юм. Иймээс ч Зоу Гуопиний илтгэлийн гол санаа хийгээд дагалдах дохио нь нийгэмд тогтсон мисожинист хэм хэмжээг улам бүр бататгаж болохуйц байна. Бид мисожинист гэх ойлголтыг охид эмэгтэйчүүдийг үзэн ядах үндэс бөхтэй үзэл гэхээсээ илүүтэй патриарх ёс дахь хууль сахиулах талбар. Жендерт суурилсан хэм хэмжээ, хүлээлтийг сахиулах, цагдах үүрэгтэй систем (Manne 2020, 8) гэх Кэйт Манны тодорхойлтын дагуу хэрэглэж буй болно. Ер нь патриархи ёсыг сахиулах гэсэн хэвшмэл үзлийн шуурганд дан ганц эмэгтэйчүүд өртдөггүй билээ. Жишээлбэл ажилд орох үйл явцын тухай “эмэгтэйлэг” талбарт ажиллахаар ажил хайж буй эрчүүд, “эрэгтэйлэг” талбарт ажил хайж буй эмэгтэйчүүдээс хавьгүй илүү ялгаврлан гадуурхалтанд өртдөг хэмээн хэд хэдэн судалгаа (Riach and Rich 2002) (Ahmed, Granberg and Khanna 2021) (Birkelund, et al. 2022) дүгнэсэн байдаг. Тухайлбал 2022 оны судалгаанд Герман, Нидерланд, Норвеги, Испани, Их Британи, АНУ гэсэн зургаан орны ажил олгогч нар тогооч, нарийн бичиг, угтагч, худалдааны зөвлөх, програм хангамж хөгжүүлэгч, дэлгүүрийн туслах гэсэн зургаан төрлийн ажилд өргөдөл гаргаж буй 4300 хүний хүсэлтэнд хэрхэн хариу үзүүлснийг судалсан байна. Аль ч орны эмэгтэй ямар ч ажилд

хүсэлт гаргахад ялгаврлалд өртөөгүй бол Герман, Нидерланд, Испанид ажил хайж буй эрчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад ажилд орох хүсэлтэнд хариулт авах хувь нь 5-9% бага байсан байна. Түүнчлэн “эмэгтэйлэг ажил” гүйцэтгэж буй эрчүүд сөрөг хэвшмэл үзлийн хандлагаас болж таагүй байдалд орох явдал түгээмэл байдаг байна. Эрчүүд давамгайлдаг талбарт ажиллаж буй эмэгтэйчүүд ажлын орчиндоо ялгавралд өртөх нь элбэг байдаг бол харин эмэгтэйчүүд давамгайлдаг талбарт ажиллаж буй эрчүүдийг уг талбараас гадна ажиллаж буй хүмүүс ялгаврладаг аж. Жишээлбэл эрэгтэй сувилагчдыг гаж, эмэгтэйлэг, ижил хүйстэн гэх мэтээр хочилж, шоглон, дорд үзэх явдал түгээмэл (Clow, Ricciardelli and J. Bartfay. 2015) байдаг гэнэ.

Эрчүүд давамгайлдаг талбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн туулж буй туршлагын тухайд бид холоос хайх шаардлагагүй юм. Хэрэв та Женнифер Саулын хөтөлдөг “Философийн талбарт эмэгтэй байх нь” (<https://beingawomaninphilosophy.wordpress.com/>) сэдэвт блог руу шагайх аваас мэргэжил нэгтнүүддээ тэнхимийн туслах гэж эндүүрэгдэх “хөнгөхөн” алдаанаас эхлээд бэлгийн дарамтийн хохирогч болсон бүсгүйчүүдийн зуу зуун түүхийг уншиж болно. Тэдгээрийн заримд дурдсанчлан эмэгтэй л бол феминист философи эсвэл халамжийн ёс зүйгээр (care ethics) судалгаа хийдэг гэж таамаглах, нэг бол ижил хүйстэн эсэхийг нь лавлах зэрэг тохиолдлуудыг философи бол “эрчүүдийн ертөнц” гэх хэвшмэл хандлагын үр дүн гэж хэлж болно. Сэлли Хаслангер (Haslanger 2008) хийгээд Чешир Калхон (Calhoun 2009) нар ч “эмэгтэй” хийгээд “философи/ философи” гэх схемийг үргэлж зөрчилт байдлаар авч үзсээр ирсэн тухай онцолж, “оюун дүгнэлт объектив байдал, философи сэтгэлгээг эрэгтэйлэг, сэтгэл хөдлөл, субъектив байдал, философи биш

сэтгэлгээг эмэгтэйлэг байдалтай холбон хардаг уламжлал философид байдаг (S. Haslanger 2008)” хэмээн Хаслангер шогширч байв.

Философийн түүх рүү хандая л даа. Эхэн үеийн фемнист бүтээлүүдийн нэг гэгдэх (Institute on gender equality and women’s history) Мэри Уолстонкрафтийн “Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалд” хэвлэгдэхээс ч өмнө бидэнд өрнөдөд Александрийн Хипатиа( ойролцоогоор 350-415), Бингений Хилдегард(1098-1179), Бохемийн гүнж Элизабет(1618-1680), Нью Кастлийн гүнгийн ахайтан Маргарет Кавендиш(1623-1673) Венецийн Елена Корнара Пископия(1646-1684), Лаура Басси(1711-1778), дорнодод<sup>2</sup> Энэтхэгийн Гарги Вачакнави(НТӨ VII зуун), Акка Махадеви(1130-1160), Хятадын Бан Зао(45-116), Солонгосын Им Южундан(1721-1793) зэрэг үе үеийн “тэрслүү охид” бий. Гэтэл зохиогчдын хувьд Софийн ертөнцөөс Хилдегард, Декартаар дамжуулан Элизабетийн тухай дуулж байснаас хэтрэхгүй, энэ өгүүллийг бичих хүртэл энэ хорвоо дээр эдгээр эмэгтэй ажиллаж, амьдарч, бүтээж, туурвиж байсан гэдгийг мэдээ ч үгүй байв. Ичгүүртэй энэ хэнэггүйрхлээ цагаатгах ганц нь Эйлеен О’Нейллийн хэлсэнчлэн эдгээр бүсгүйчүүд бүтээл туурвилаа “арилдаг бэх”-ээр (O’Neill 1998) бичсээр ирсэн мэт байна гэх өр өвдөм тайлбар л байна. Философийн түүхийн шаргал хуудаснаа зүүлт тайлбар маягаар л зүүгдэж ирсэн эмэгтэй философичдийн нэрс нэг л мэдэхэд түүхэн ой санамжаас арчигдчихсан байгааг XX зууны төгсгөлд олж харснаа О’Нейлл ийнхүү “арилдаг бэх” хэмээн егөөджээ. Энэхүү дүр зураг XXI зуунд өөрчлөгдсөн үү? гэж асууваас

харамсалтай нь “бага зэрэг л” гэж хариулж болохоор мэт. Жишээлбэл философийн ангийн оюутнаас асуух хамгийн амархан асуултын нэгд “Өөрийн мэдэх арван философичийг нэрлээч” гэх асуулт багтах авч “эмэгтэй” гэх ганц үг нэмээд л уг асуултыг эрс хүндрүүлж болно. Людвиг Максимилианы их сургуульд 2013-2017 оны хооронд философиор суралцаж байсан бакалаврын оюутнуудаас нэмэлт эх сурвалж, материал харалгүйгээр өөрсдийн мэдэх 5 эрэгтэй, 5 эмэгтэй философичийг нэрлэх асуулт асуухад судалгаанд оролцсон оюутнуудын 92% нь 5 эрэгтэй философичийг нэрлэсэн бол дөнгөж 6% нь 5 эмэгтэй философичийг нэрлэж чадсан байна. Оюутнуудын 17% нь нэг ч эмэгтэй философич нэрлэж чадаагүй байна (Herfeld, J and K 2022). Энэхүү судалгааны тухайд бид философи гэх мэдлэгт суралцаж буй болохоос тухайн мэдлэгийг “хэн бүтээсэнд” нь суралцах албагүй гэж мэтгэж болох ч ийнхүү ялгаж харж байж л “дайвар хүйстний” ондоо дуу хоолой тухайн талбарт сонсогдож буй эсэхийг шалгаж түншиж дөнгөх билээ. Энд “ноёлж буй өгүүлэмжээс” ялгаатай туршлага, өөр дуу хоолой нь философийн хүрээг тэлж, шинэ шинэ асуултууд, өөр өөр эрэлхийллийг авч ирдэг ач холбогдолтойг дурдах нь зүйтэй. Мэдлэгийн зүй бус байдал хийгээд хүүхэд, жирэмслэлт ба метафизик, халамжийн ёс зүй зэрэг сэдвүүд философид хүч түрэн орж ирсний шалтгааны Квилл Кукла “өнөөдөртэй харьцуулахад эрчүүдийн урьд урьдын цаг үед<sup>3</sup> илүү давамгайл байсантай холбоотой байж мэднэ” хэмээн тэмдэглэсэн байдаг. Уламжлал ёсоор бол бүсгүйчүүд “бэлгийн харилцаа, асрал халамж, өсгөж хүмүүжүүлэх, нөхөн үржихүй” зэрэг эмэгтэйлэг “таваарыг” нийлүүлэх ёстой байдаг билээ (Manne 2020, 11). Тиймээс ч

<sup>2</sup> Энд дурдаж буй философичдийн тухай уншихыг хүсвэл Dag Herbjurnsrud, (2018), *First women of philosophy*, *Aeon magazine*, url: <https://aeon.co/essays/before-the-canon-the-non-european-women-who-founded-philosophy> -ээс үзнэ үү.

<sup>3</sup> Агуулгыг харгалзан нэмж орчуулав.

эдгээр сэдэв эмэгтэйчүүдийн хувьд илүү ойр байж, “нэгдүгээр биеийн үүднээс” мэдэрсэн туршлага нь цаашдын судалгаа шинжилгээнийх сэдэл болох нь бий. Гэрийн буюу ойкосын хүрээний, хүн бүрт танил авч хараанаас гадуур өнгөрөөх асуудлуудыг өлгөн авч, өөр өнцгөөр харах ойлголт, ойлголтын аппаратыг санал болгоход хувийн туршлага нэмэр болдог нь дамжиггүй. Гэхдээ нөгөөтэйгүүр эмэгтэйчүүд философидохын тулд заавал “эмэгтэйлэг” сэдвүүдийг онцлон судлах албагүй гэдгийг онцолмоор байна. Ийнхүү эмэгтэйлэг таваарт холбогдох сэдэв, хүйс хоёрыг шууд холбон ойлгох аваас “патриархи хэм хэмжээ, хүлээлтийг рационалчилж, натуральчилах зориулалттай итгэл үнэмшил, үзэл санаа, хүлээлт хандлага болох сексизмийг” (Manne 2020, 8) сурталчилж буй хэрэг болно. Түүнчлэн эмэгтэйчүүд философид ийнхүү хувь нэмрээ оруулж байна гэж онцлохдоо тухайн өнцөг бол хэн нэгэн философичийн бүтээл биш харин тэр нэгэн эмэгтэйн бодол хэмээн буулган бодох аваас буцаад л “эм хүн үс урт, ухаан богино” хэмээн мэтгэлцсээр байгаагаас ялгаагүй юм. Өрөвдөлтэй хийгээд зөрчилтэй нь хүүхнүүдийн философидолтыг “энгийн, хэвийн” хэм хэмжээ болгохын тулд бид буцаад тэгш оролцоог хангаж чадаж байна уу гэдэг өнөөх асуулт, хүйсийн харьцааг анзаарсан нөгөө л тоо баримт руугаа өнгийн харах хэрэг гарна.

Тийнхүү өнгийсөн нь ч тодорхой утгаар ач тусаа өгсөөр буйг Хэлен Бээбээ болон Женнифер Саул нарын бичсэн “Философид буй эмэгтэйчүүд-Их Британид” сэдэвт 2011 болон 2021 оны тайлангаас харж болно. Тухайлбал 2011 онтой харьцуулахад 2021 онд эмэгтэй оюутнуудын эзлэх хувь бакалаврын түвшинд 4%-иар, магистрын түвшинд 3%-иар, докторын түвшинд 2%-иар, байнгын

албан тушаалд ажиллаж буй багш нар 6%-иар тус тус өссөн байна (Beebee and Saul 2021, 5). Мэдээж энэхүү ийнхүү өөрчлөлт гарахад энэхүү судалгаа л нөлөөлсөн гэж хэлж болохгүй. Энэхүү судалгаанаас санаа авч дагалдсан, зэрэгцсэн бусад судалгаа хийгээд засгийн газар, сургуулийн зүгээс авч хэрэгжүүлсэн бодлого, төсөл хөтөлбөрүүд чухал үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй. Тухайлбал Британийн философийн холбоо, Их Британид буй эмэгтэй философичдийн нийгэмлэг хамтарч 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Сайн Туршлага” хөтөлбөр, 2017 оны #metoo хөдөлгөөн, их дээд боловсролын түвшинд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих Афин СВМ шагнал, Их Британид засгийн газраас 250-иас дээш ажилтантай байгууллагууд жил бүр хүйстэй уялдаатай цалингийн зөрүүг тайлагнах ёстой дүрэм гаргасан зэрэг улс төр, эдийн засаг, соёлын шинжтэй ажлууд томоохон түлхэц болсон (Beebee 2021). 2021 оны тайланд дурдсанчлан 2011 онд философийн талбар дахь эмэгтэйчүүдийн оролцооны тухай эмпирик судалгаа бараг байгаагүй бол өдгөө уг талбарт холбогдох бакалаврын түвшинд философийн удиртгал сонгож үзэж байгаа оюутнуудын дунд явуулсан судалгаанаас эхлээд философийн талбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо бага байхад сэтгэл зүй, нийгэм эдийн засгийн хүчин зүйл хэрхэн нөлөөлдөг тухай, философийн сэтгүүлд хэвлүүлж буй эмэгтэй зохиогчдын хувь хэмжээ зэрэг олон асуудал хөндсөн, улс бүрийнхээ онцлогийг харгалзсан өгүүлэл, нэг сэдэвт бүтээл хэвлэгдсээр байна<sup>4</sup>.

Эдгээр судалгаанаас зохиогчдийн хувьд хамгийн сонирхол татсан сэдэв нь хэвшмэл үзлийн занал хийгээд далд өрөөсгөл хандлагад холбогдох судалгаа байв. Тухайн хүнд буй аль нэг бүлгийн тухай өрөөсгөл хандлага нь тухайн бүлгийн

4 Агуулгыг харгалзан нэмж орчуулав.

гишүүнтэй харилцах, үнэлэх, хүлээж авах үед ухамсаргүй байдлаар илэрч, нөлөөлөх үзэгдлийг далд өрөөсгөл хандлага гэдэг. Далд өрөөсгөл хандлага нь эерэг хийгээд сөрөг аль аль хүлээлтийг илэрхийлж болох агаад тухайлбал олонхи хүн нүдний шилтэй хүмүүсийг ухаалаг хэмээн хардаг билээ. Философичдод далд өрөөсгөл хандлага хэрхэн илэрдэг тухай Ди Белла болон хамрагчдынх нь хийсэн судалгаа ёсоор философичид философийг эрэгтэйлэг байдалтай холбон илэрхийлж байсан аж. Харин ил тод илэрхийллийн түвшинд биш, далд, дотоод хамаарлын тухайд эрчүүд философийг эрэгтэйлэг байдалтай холбож харах хандлагатай аж. Харин эмэгтэйчүүд философийг эрэгтэйлэг байдалтай холбож харах хандлага байгаагүй агаад, уг талбарт илүү их цаг зарцуулах тусмаа философийг эмэгтэйлэг байдалтай нийцүүлж хардаг байна. Гэхдээ уг судалгаанд эдгээр далд хандлага нь ажилд авах, дүгнэх, хичээл заах зэрэг үйлдэлд нөлөөлдөг эсэхийг гүнзгийрүүлэн судлаагүй агаад, цааш судалваас зохистой болохыг онцолжээ (Bella, Miles and Saul 2016). Философи өөрөө олон талт, баялаг талбар тул эрэгтэйлэг эсвэл эмэгтэйлэг байх "ёстой" хэмээх норматив асуулт бол мэдээж утгагүй. Харин уг судалгаанд дурдсанчлан өдөр тутмын амьдралдаа хувь судлаачид уг талбарыг хэрхэн ойлгож, авч үзэж энэ нь буцаад бусдын ертөнцийг үзэх үзэл, дүн, урам зориг, ажилд орох эсэхэд хамаарах тухай практик асуултыг сонирхож буй нь зүйн хэрэг билээ. Ялангуяа "Эмэгтэйчүүд ба философи" гэх сэдэвт симпозиумд оролцож буй илтгэгч нь "Эмэгтэйчүүд философидох хэрэггүй" хэмээн ил тодоор зарлан тунхаглах тохиолдол гардаг талбарт ийнхүү түншсэн эмпирик судалгаа тун чухал юм. Нөгөөтэйгүүр философидох тусам эмэгтэйчүүд философийг "эмэгтэйлэг байдалтай" холбон харж байна гэдэг нь философи аваас уян хатан, задгай, чөлөөт талбар гэдгийн бас нэгэн

илэрхийлэл биз ээ.

Далд өрөөсгөл хандлагатай төстэй авч, энэ удаад "өртөгдөж буй" байдлаар биш харин өртөж буй хүний өөрийгөө харах өнцөгт нь нөлөөлдөг сэтгэл зүйн үзэгдлийг хэвшмэл үзлийн занал гэдэг. Клауде Стилл, Жошуа Аронсо нар анх "өөрийн багтаж буй бүлэгт хамаатай сөрөг хэвшмэл үзэлтэй холбоотой нөхцөл байдалд байгаа эсвэл үйлдлийг гүйцэтгэж байх үед хувь хүнд илэрдэг нийгмээс нөхцөлдсөн сэтгэл зүйн занал (Steele C and Arson 1995) " хэмээн тодорхойлсон юм. Өөрөөр хэлбэл энэ бол арьс, үндэс угсаа, жендер эсвэл соёлын аль бүлэг хамрагдаж байгаагаасаа хамааран тухайн бүлэгт хамаатай сөрөг хэвшмэл үзлийг бататгах вий гэх ухамсарт хийгээд ухамсарт бус айдас нь төвлөрөл хийгээд гүйцэтгэлд нь сөргөөр нөлөөлөх үзэгдэл юм. Хэвшмэл үзлийн заналын нөлөө тун тод байдаг. Тухайн занал учруулж буй нөхцөлд стандарчлагдсан шалгалтыг хар арьстай хүмүүс цагаан арьстнуудаас муу гүйцэтгэж, охид математикт хөвгүүдээс дор байж, спортод цагаан арьстай хүмүүс хар арьстнуудыг гүйцэхгүй байдаг аж. Харин тухай заналыг арилгахад гүйцэтгэл нь эрс сайжирдаг байна (Steele 2010, 35).

2012 онд хийсэн судалгаа ёсоор философийн удиртгал хичээл судалсан оюутнуудаас философи сонгох завсарт эмэгтэй оюутнуудын эзлэх хувь эрс цөөрдөг аж (Paxton, Fidgor and Tiberius 2012, 955). Ийнхүү огцом өөрчлөгдөхөд хэвшмэл үзлийн занал нөлөөтэй эсэх талаар хийсэн хэд хэдэн судалгаа байдгаас Жина Шоутен (2015), Сам Барон ба бусад (2015), Катерин Херфелд болон бусад (2021) нарын судалгааг дурдъя. Жина Шоутен хэвшмэл үзлийн заналын нөлөө нь оюутнуудын мэргэжил сонголтонд нөлөөлөх гурван суурь нөхцлийг дэвшүүлсэн юм. Үүнд нэгдүгээрт тухайн талбарт хамаарах өөрсдийн бүлгийн тухай сөрөг хэвшмэл үзлийг мэддэг байх, хоёрдугаарт уг сөрөг

хэвшмэл үзлээс үүдэлтэй гүйцэтгэлийн эрс тод ялгаа байх, гуравдугаарт тухайн хүн өөрийгөө уг талбартай холбож үзэн тодорхойлох явдалд нь хэвшмэл үзлийн занал хүчтэйгээр нөлөөлдөг байх аж. Түүнийхээр бакалаврын түвшний оюутнууд философийн тухай ерөнхий ойлголт хангалттай авахгүйгээр удиртгал хичээл судалдаг тул хийсвэр аналитик сэтгэлгээндээ эрэгтэйчүүд илүү гэх хэвшмэл үзлийн заналд өртөх бололцоо тэр бүр гарахгүй агаад иймээс ч хэвшмэл үзлийн заналын суурь нөхцөл болсон “түгшүүр төрүүлэх” нөхцөл биелэгддэггүй аж. Удаах нөхцөл болох “гүүр нөхцлийн” тухайд философийн талбарт эмэгтэйчүүдийн гүйцэтгэл дутуу байдаг нь системтэй үзэгдэл болох тухай судалгаа хараахан гараагүй аж. Талбараар өөрийгөө тодорхойлох тухай гурав дахь нөхцлийн хувьд АНУ-ын тухайд философийн удиртгал хичээл авч буй оюутнуудын цөөхөн хувь нь л тухайн талбарыг өөрийн үнэ цэнэ, өөртөө итгэх итгэлтэйгээ холбон үздэг аж. Гэхдээ ийнхүү үзэж буй нь хэвшмэл үзлийн заналыг асуудлын төвөөс салган гаргах шалтгаан болохгүй гэдгийг ч тэрээр онцолсон юм (Schouten 2015). Шоутен АНУ-ын оюутнуудын нөхцөл байдлыг харгалзан авч үзэхийн сацуу, ерөнхий хандлагын хүрээнд эргэцүүлэл хийсэн бол Сам Бароны багийнхан Сидней Их сургуулийн оюутнууд дунд судалгаа хийсэн юм. Тэд 2013 онд Философийн удиртгал, Бодит байдал, Гоо сайхан ба ёс зүй гэсэн хичээлүүдийг судалсан нэгдүгээр курсийн 609 оюутныг судалгаандаа хамруулсан агаад судалгаанд оролцсон эрэгтэй оюутнууд эмэгтэй оюутнуудтайгаа харьцуулахад философийг илүү сонирхолтой байна гэж дүгнэхийн сацуу, эмэгтэй оюутнууд өөрсдийгөө эрэгтэй оюутнууд шиг сайн философидож чадна гэж үзээгүй байна. Мөн харьцангуй цөөн эмэгтэй оюутан өөрсдийгөө философич болно гэж харсан агаад ангид хэлэлцүүлэгт

оролцохдоо тухтай байна гэж хариулсан аж (Baron, Dougherty and Miller 2015). Катерин Херфелд болон түүний багийн 2014 онд хийсэн эмпирик судалгаа ч үлгэр жишээ болох эмэгтэй философичдийн тоо цөөн байх, хэвшмэл үзлийн занал, далд өрөөсгөл хандлага зэрэг нь эмэгтэй оюутнуудын философиор цааш суралцах хүсэлд сөргөөр нөлөөлдөг байж мэднэ гэж дүгнэсэн юм (Herfeld, J and K 2021). Хэвшмэл үзлийн занал нь ялангуяа эмэгтэй сурагчдын ангид идэвхитэй оролцохгүй байх, математикийн хичээлийн гүйцэтгэл нь сул байх зэргийн шалтгаан байж болох юм.

Далд өрөөсгөл хандлага хийгээд хэвшмэл үзлийн заналын эсрэг “оюутнуудад эмэгтэй философичид байдаг төдийгүй амжилттай философиддог гэдгийг харуулах (Beebe and Saul 2021)” хамгийн хялбар хийгээд хүртээмжтэй арга юм. Тухайлбал аналитик уламжлалыг түлхүү барьдаг хөтөлбөр бүхий “оюун санааны философи” хичээл дээр Декартын дуализмын тухай ярилцсны дараа Бохемийн гүнж Элизабетийн Декартад бичсэн хариу захидлыг уншиж ярилцахад болохгүй гэх газар үгүй билээ. Түүнчлэн сэтгүүлд өгүүлэл хүлээж авах, оюутны ажлыг дүгнэхдээ нэрийг кодчлон дүгнэх, далд өрөөсгөл хандлага, хэвшмэл үзлийн заналын тухай мэдэгдэхүүнтэй болох зэрэг нэг дор хэрэгжүүлж болох аргуудыг (Saul 2013) Женнифер Саул дурсан. Уг аргууд хийгээд философид уяатай эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төслүүдийн үр дүнд эрдэм шинжилгээний хурал илүү нөхөрсөг, конструктив уур амьсгалтай байх болж (Murphy 2018), бакалаврын түвшний унших эх зохиолын жагсаалт, эрдэм шинжилгээний хурал, уулзалтанд оролцох эмэгтэйчүүдийн тоо эрс нэмэгдсэн агаад философийн түүхийн сүүдэрт нуугдсан эмэгтэйчүүд ил гарч, тэдэнд зориулагдсан хурал, өгүүлэл, ном, цуглуулга хэвлэгдэх болсныг” (Beebe

2021) Хэлэн Бээбээ онцолсон байдаг. Хэдий асуудал, асуулт, хийх ажил байсаар байгаа авч чимх ямхаар ахиц гарсаар л байна.

Нөгөөтэйгүүр философид эмэгтэйчүүд “цөөнх” байна гэх баримтыг “няцаах” судалгаа ч байдаг агаад тухайлбал 2017 он Шон Аллен-Хермансон АНУ-д залуу философчдын ажилд орох хийгээд хийгээд өгүүлэл хэвлүүлэх байдал дээр дүн шинжилгээ хийгээд энд тэнд хэдэн хувь дурдаж дэмий цэцэрхсэн дор сүүлийн арван жилд байнгын албан тушаалд дэвших боломжтой ажилд шинээр орж буй философчдын дунд эмэгтэйчүүд хангалттай байна гэдэгт санал нэгдэе гэж уриалсан юм. Тэрээр Америкийн философийн холбооны тайлан мэдээ хийгээд Женнингийн хийсэн 2012, 2013 оны судалгаан дээр тулгуурлан 229 эрэгтэй, 109 эмэгтэйчүүд бүхий өгөгдөл дээр задлан шинжилгээ хийсэн байна. 2004-2014 оны мэдээлэл дээр анализ хийгээд эмэгтэйчүүд байнгын албан тушаалд өрсөлдөх (tenure track), өгүүлэл хэвлүүлэх, төгссөн хийгээд ажилд орж буй тэнхимийн зэрэглэл зэрэг объектив хэмжүүрээр харахад сул талтай байна гэх баримт алга байгааг онцолжээ. Тухайлбал 2009-2014 онд ажил хайж байсан эрчүүдийн 35,3% нь эмэгтэйчүүдийн 46,7% нь байнгын орон тоонд ажиллах боломжтой албан тушаалд (tenure track) орсон байна. Энэ нь ажилд орох магадлалд эмэгтэйчүүдэд 30 орчим хувиар илүү байна гэсэн үг юм. Тэрээр өөрийн судалгаагаа философичдийн сексист хандлага (ухамсарт хийгээд ухамсаргүй) нь жендерийн хувьд ялгаа үүсэх гол шалтгаан хэмээх таамаглалыг няцааж буй судалгаануудын жагсаалтыг ийнхүү нэгээр нэмж байна хэмээн өгүүлсэн байдаг (Sean 2017). Харин Каролин Женнингс болон Алекс Дайер нар 2021 оны Америкийн философийн холбооноос гаргадаг академик ажилд орох процедурын тухай өгөгдөл

ба анализ гэх тайландаа байнгын албан тушаалд дэвших ажилд орох магадлал эмэгтэйчүүдэд 85 хувиар илүү байна гэж дүгнэсэн авч философийн докторант оюутнууд дунд эмэгтэйчүүд, гэрээсээ анх удаагаа коллежид суралцаж буй оюутнууд, цэргийнхэн болон хэд хэдэн угсаатны бүлгүүд цөөнх байна гэдгийг онцолжээ. Тэдний судалгаанд 1023 хүн хариулснаас хүйсээ тодорхойлсон нь 741 байж, үүний 198 буюу 26,6-26,7% нь эмэгтэйчүүд байсан аж. Энэ нь 2020 оны байдлаар Америкийн философийн холбооны гишүүдийн 26,5% эмэгтэйчүүд байна гэдэгтэй ойролцоо байхын сацуу, 2019 оны байдлаар АНУ-д доктороор суралцаж буй оюутнуудын 54,3% нь эмэгтэйчүүд байна гэдэгтэй харьцуулахад бага хувь байгаа юм. (Jennings and Alex 2022) Тэгэхээр эмэгтэй төгсөгчдийн ажилд орох боломж өндөр байгаа шалтгааныг зүй бус ялгаврлан гадуурхалтын эсрэг хэрэгжүүлдэг алхам болох дэмжих үйлдэлтэй холбож тайлбарлах бололцоо байхын сацуу угаас цөөн байгаа төгсөгчдөөс ажилд орох магадлал нь өндөр байна гэдгээс бүх юм “зүгээр” гэж харж болох уу гэдэг асуулт урган гарч ирж байгаа юм. Сайтар бодвоос байнгын орон тоонд дэвших бололцоо бүхий албан тушаал гэдэг нь байнгын орон тоонд ажиллаж байна гэсэн үг биш билээ. Тухайлбал Адриан Ринигийн бүртгэснээр 2005 оны долоон сараас 2013 оны 4 сарыг дуустал Шинэ Зеландад байнгын албан тушаалд 20 эрэгтэй багш, нэг эмэгтэй багш томилогдсон агаад ганц эмэгтэй багш нь хагас цагаар ажиллахаар гэрээ байгуулсан (Rini 2013, 127) баримт байдаг. Женнифер Саулын (Saul 2013, 45) дурдсанчлан эмэгтэйчүүдийн харилцааны хийгээд бусдад туслах чадвар илүү гэж үздэг тул оюутнуудад туслах, захиргааны ажил зэрэг цаг их зарцуулдаг ч албан тушаал дэвшихэд нөлөө багатай ажилд хуваарилагдах нь их байдгийг мартаж болохгүй юм. Энэ нөхцөл байдал нь АНУ-д байнгын албан



тушаалд дэвших боломжтой ажилд орж буй эмэгтэйчүүдийн хувь өндөр байгаа авч, байнгын профессороор ажиллаж буй хувь нь бага байгаагийн тайлбар байж мэдэх юм. Ажлын талбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэх төдийд мисожинист суурьтай байгууллагийн бүтцийг бүрэн дүүрэн өөрчлөхгүй билээ. Хүйс эсвэл яс үндэс нь мэргэжлийн хувьд цааш ахиж дэвшихэд нь саад болдог “шилэн таазанд” (Cotter, бас бус. 2001) эдгээр эмэгтэйчүүд тулж байж мэднэ.

2022 онд Хятадын философи сэтгүүлийн 50 жилийн ойд зориулан гаргасан философи дахь эмэгтэйчүүд эмхэтгэлийн өмнөтгөлд “Хэрэв Өрнөдөд эсвэл Хятадад буй эмэгтэйчүүд философи судлах ёсгүй гэж харж байвал энэ нь эмэгтэйчүүдийн биш, харин гадаад хүчин зүйлийн буруу юм (Cheng 2022, 3)” хэмээн Чен Чун Ин өгүүлснийг ч энд мөн онцлууштай. Өөрөөр хэлбэл философийн профессороор эмэгтэйчүүд ажиллаж “чадахгүй” байгаадаа биш харин хүлээж буй хүлээлт, тавьж буй шаардлага, ажлын байрны орчин зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөг бид харгалзах хэрэгтэй. STEM талбарт болон бусад талбарт ахлах албан тушаалд орохоосоо урд бүсгүйчүүд ажлын байранд тулгарч буй саад бэрхшээлээс болон ажлаа орхих үзэгдлийг “цоорхой шугам” (Goulden, Ann Mason and Frasch 2011) гэж зүйрлэн хэрэглэх нь бий. Энэхүү “цоорхой шугам” философийн талбарт ажиллаж буй бүсгүйчүүдийг тойрохгүй нь мэдээж билээ. Дээр дурдсан хэвшмэл үзлийн занал, далд өрөөсгөл хандлага зэрэг субъектив туршлагаас гадна ажлын байран дахь мисожинист хандлага, ил далд илрэх сексизм, цалингийн зөрүү, албан тушаал ахих боломж гээд олон олон бэрхшээлүүд академик талбарт ажиллаж буй бүсгүйчүүдийн өмнө тосон хүлээж, араас нь шил даран мөшгөж байдаг гэхэд хилдсэхгүй юм.

### *Дүгнэлт*

Өгүүллэгээ дүгнээд сексист хандлагад тулгуурлан аливаа талбарыг “эрэгтэйлэг” эсвэл “эмэгтэйлэг” гэж дүгнэх нь хортойн зэрэгцээ, энэ байдал нь хүн төрөлхтөн нийтдээ өөрсдийн бүтээсэн гинжиндээ хүйс харгалзахгүй дөнгөлөгдчихөөд гарах гарцаа эрэлхийлсээр байгаагийн бас нэгэн жишээ болж байна хэлж болохоор санагдана. Тохиолдол болгон авсан философийн талбарын тухайд хүмүүнлэгийн бусад талбартай харьцуулахад эмэгтэйчүүд цөөхөн байгаагийн шалтгааныг түүхэн эх зохиол дээр төвлөрөн ажилладаг талбарын онцлог, философийг эрэгтэйлэг байдалтай холбон авч үздэг тогтсон хандлагатай холбон тайлбарлаж болох аж. Мэдээж уг шалтгаан дээр “эмэгтэй” хүнд тулгардаг хэвшмэл үзлийн занал, далд өрөөсгөл хандлага, шилэн тааз, бага цалин, ажлын байран дээрх сексист хандлага гээд олон үзэгдэл хүч нэмж буй нь тодорхой. Тоо нэмэх төдийгөөр асуудал бүрэн шийдэгддэггүй болохыг ажилд орж буй залуу философичид хийгээд профессороор ажиллаж буй философичдийн хүйсийн харьцаан дээрээс олж харж болохуйц байна. Гэхдээ философид эмэгтэйчүүд цөөнх байсаар ирсэн, байсаар байгаа шалтгааныг сонирхон харж, дэлгэн судлах нь уг талбарт тэгш оролцоог хангах, талбарын хүрээ хязгаарыг тэлэх санаа сэдэл, гарц шийдэл өгсөөр иржээ. Жишээлбэл Их Британий философийн тэнхимүүдийн Сайн туршлага хөтөлбөрийг хэрэгжүүлж, унших эх зохиолын жагсаалтанд эмэгтэй философичид харагдах болж, хурал уулзалт илүү эвсэг нөхөрсөг шинжтэй байж, тэдгээрт оролцож буй эмэгтэйчүүдийн хувь хэмжээ нэмэгдэж, эмэгтэй философичдийн бүтээл өргөнөөр хэвлэгдэж, дуу хоолой нь улам “чангарч” буй явдал бол өнөөх л уйгагүй судалгаа, байнгын түншилтийн үр дүн билээ. Мөн философийн талбар ч халамжийн ёс зүй, жирэмсэн үеийн

метафизик зэрэг шинэ сонин содон сэдвүүдээр баяжсаар байна. Иймээс ч “арилдаг бэхээр” философи бүтээл бичдэг байсан бүсгүйчүүд өдгөө ч тогтсон хандлага, хэвшмэл үзлийн хүлээсээс бүрэн ангижраагүй байна авч тэгш оролцоог

хангахын тулд чимх ямхаар, сөөм сөөмөөр судалгаа шинжилгээний хийгээд, бодлогын шинжтэй ажлууд хийсээр, үр шим нь гарсаар байна гэж өөдрөг дүгнэж болохоор байна.

### ХАВСРАЛТ

Англи хэлт орнуудад төвлөрсөн судалгаа их, баримт олонд дулдуйдан тэдний ажлын үр дүнг энэ хүртэл дурдсан тул одоо өөрсдийн нөхцөл байдал руу өнгийн харснаа хавсаргав. Манайд, тэр дундаа МУИС-ийн философийн талбард суралцаж, ажиллаж байсан, байгаа эмэгтэйчүүдийн тухай тоон мэдээг бид Философийн тэнхимийн 45 болон 50 жилийн ойд тус тус зориулан гаргасан ном хийгээд, МУИС-ийн их сургуулийн цахим хуудсанд байгаа төгсөгчдийн мэдээлэлд үндэслэн гаргав. Философи, шашин судлалын тэнхимд ажиллаж байсан, ажиллаж байгаа багш нарын тухайд 1990 оноос өмнө ажиллаж байсан багш нарын хүйсийн тухай мэдээлэл байхгүй байсан агаад зөвхөн Ж. Сосор нь Марксизм-Ленинизмын тэнхим буюу одоогийн философи шашин судлалын тэнхимийн анхны эмэгтэй багш гэсэн мэдээ (М.Отгонбаяр 2015, 10) байв.

тушаалд буй эмэгтэйчүүдийн хувь 20-30% байсан билээ) дөхүү байсан авч 2014 оноос хойш өөрчлөгдсөн байгааг харж болно. 2014 оноос Философийн тэнхим нь шашин судлалын тэнхимтэй нэгдэж, Философи шашин судлалын тэнхим болсон явдал хийгээд, тухайн чиглэлээр суралцаж, төгссөн оюутны хүйсийн харьцаа нөлөөтэй байж болох билээ. Түүнчлэн 1990 оноос өмнө нийгэмд философийг хэрхэн ойлгож, хүлээж авч байсан явдал, 1990 оноос хойш хэрхэн өөрчлөгдсөн тухай ялгаа ч нөлөөлсөн эсэхийг судлууштай. Гэхдээ хэдэн арваас хэдэн зуун тэнхимийн өгөгдлийг үндэслэн бусад улсууд мэдээллээ гаргасан бол бид энд зөвхөн МУИС-ийн ганц л тэнхимийг авч үзэж буйг анзаарна уу.

Философийн салбараар суралцаж төгсөгчдийн тоон мэдээг, 2021 онд Хэлэн Бээбээ болон Женнифер Саул тайланд тусгасан философийн салбарт суралцаж буй оюутнуудын тоотой харьцуулан хүснэгт 3-д үзүүлэв. МУИС-ийн салбарын тухайд хэдэн арван жилийн турш байгаа нэг тэнхимийн төгсөгчдийн мэдээг, Их Британи улсын хэдэн зуун тэнхимүүдэд нэг жил суралцаж буй оюутнуудын тоотой харьцуулсан нь тэгш бус боловч, ерөнхий бүдэг зураг, барагцаа төсөөлөл харахад хэрэг болох байх хэмээн бодож ийнхүү харьцууллаа.

	Тэнхимийн түүхэн бүрэлдэхүүн	Он	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт <sup>1</sup>
1	Марксизм-Ленинизмын тэнхим	1947-1963			38
2	Марксист Ленинист философийн тэнхим	1963-1990			35
3	Философийн тэнхим	1991-2014	17(65%)	9(35%)	26
4	Философи, шашин судлалын тэнхим	2014 оноос	12(54%)	10(46%)	22

(Хүснэгт 2)

Эндээс 1991-2014 оны хооронд ажиллаж байсан багш нарын хүйсийн харьцаа дээр дурдсан бусад орнуудынхтай (Өмнө дурдсан АНУ, Их Британи, Грек зэрэг улсуудын тухайд профессорын албан


<sup>1</sup> Тухайн заасан хугацаанд багшилж байсан, байгаа багш нарын тоог гаргахдаа жил бүрийн цалингийн цэснээс давхардуулалгүй тоолж гаргасан мэдээ болно.

МУИС, философийн салбарын төгсөгчид			Их Британи 2021 оны өгөгдөл, философиор суралцаж буй оюутнууд		
Түвшин	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Нийт оюутны тоо	Түвшин	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Нийт оюутны тоо
Бакалавр(1970-2022)	58,4%	767	Бакалавр	48%	3022
Магистр(1995-2022)	58,2%	103	Магистр	48%	911
Аспирантур(1990-2002)	50%	14	Докторантурт элссэн	33%	268
Доктор(2005-2022)	62,5%	16	Доктороо төгссөн	32%	157


(Хүснэгт 3)

Мөн философийн талбарыг бакалаврын зэргээр төгсөгчдийн тоо он бүрд хэрхэн өөрчлөгдөж ирсэн нь дараа дараагийн судалгааны ажлын сэдэл байж болох юм хэмээн дараах хоёр графикаар дүрслэв.

### Бакалаврын төгсөгчид(тоогоор)



### Бакалаврын төгсөгчид(хувиар)



**Ном зүй:**

1. М.Отгонбаяр. 2015. МУИС-ийн философийн салбар 50 жилд, Өчигдөр, өнөөдөр. Улаанбаатар: МУИС пресс.
2. Д.Тунгалаг. 2010. Философийн салбар 45 жилд (Түүхэн тэмдэглэл, дурдатгал дурсамж). Улаанбаатар.
3. n.d. Төгсөгчдийн мэдээлэл. <https://www.num.edu.mn/home/Content/272>.
4. Ahmed, Ali, Mark Granberg, and Shantanu Khanna. "Gender discrimination in hiring: An experimental reexamination of the Swedish case." *PloS one* 16, no. 1 (2021): e0245513.
5. Baron, Sam, Tom Dougherty, and Kristie Miller. 2015. "Why Is There Female Under-Representation among Philosophy Majors? Evidence of a Pre-University Effect." *Ergo* 2 (14).
6. Beebee, Helen. 2021. "Women in Philosophy What's Changed?" *The Philosophers' Magazine* (93): 50-56.
7. Beebee, Helen, and Jennifer Saul. 2021. *Women in Philosophy in the UK*. British Philosophical Association and Society for Women in Philosophy UK.
8. Bella, Laura Di, Eleanor Miles, and Jennifer Saul. 2016. "Philosophers Explicitly Associate Philosophy With Maleness: An Examination of Implicit and Explicit Gender Stereotypes in Philosophy." In *Implicit Bias and Philosophy: Metaphysics and Epistemology*, edited by Michael Brownstein and Jennifer Saul, 25-53. Oxford university press.
9. Budden, A., Tregenza, T., Aarssen, L., Koricheva, J., Leimu, R. and Lortie, C. 2008. "Double-Blind Review Favours Increased Representation of Female Authors." *Trends in Ecology and Evolution* 23 (1): 4-6.
10. Calhoun, Cheshire. 2009. "The undergraduate pipeline problem." *Hypatia* 24 (2): 216-223.
11. Cheng, Chung-Ying. 2022. "Women and Men Philosophers as Equal Partners." *Journal of Chinese Philosophy* 49: 3-4.
12. Goulden, Marc, Mary Ann Mason, and Karie Frasch. "Keeping women in the science pipeline." *The ANNALS of the American Academy of Political and Social Science* 638, no. 1 (2011): 141-162.
13. Cotter, David A., Joan M. Hermsen, Seth Ovadia, and Reeve Vanneman. "The glass ceiling effect." *Social forces* 80, no. 2 (2001): 655-681.
14. Clow, Kimberley A., Rosemary Ricciardelli and Wally J. Bartfay. "Are You Man Enough to be a Nurse? The Impact of Ambivalent Sexism and Role Congruity on Perceptions of Men and Women in Nursing Advertisements." *Sex Roles* 72 (2015): 363-376.
15. Friedman, Marilyn. 2013. "Women in Philosophy: Why should we care?" In *Women in Philosophy: What needs to change*, edited by Katrina Hutchison and Fiona Jenkins, 21-39. Oxford: Oxford University Press.
16. Haslanger, Sally. 2008. "Changing the ideology and culture of philosophy: Not by reason (alone)." *Hypatia* 23 (2): 210-213.
17. Herfeld, C, Мьллер J, and von Allmen K. 2021. "Why Do Women Philosophy Students Drop Out of Philosophy? Some Evidence from the Classroom at the Bachelor's Level." *Ergo* 8 (51): 741-786.
18. Illiadi, Simoni, Kostas Theologou, and Spyridon Stelios. 2018. "Is the Lack of Women in Philosophy a Universal Phenomenon? Exploring Women's

- Representation in Greek Departments of Philosophy.” *Hypatia* X (X): 1-17.
20. Jennings, Carolyn Dicey, and Dayer Alex. 2022. “Academic Placement Data and Analysis (APDA) 2021 survey of philosophy Ph.D. students and recent graduates: Demographic data, program ratings, academic job placement, and nonacademic careers.” *Metaphilosophy* (53): 100-133.
21. Kalnick6, Zdeňka. 2021. “The First Woman Philosopher with a Doctorate: Elena Cornaro Piscopia.” *Studies in the History of Philosophy* 12 (3): 97-121.
22. Klonschinski, Andrea, and Tim Kraft. 2022. *Leaky Pipeline oder Women Only? Berufungen im Fach Philosophie an deutschen Universitten*. <https://swip-philosophinnen.org/wp-content/uploads/2022/08/Klonschinski-Kraft-2022-Berufungen-Philosophie.pdf>.
23. Kukla, Rebecca, and Mark Lance. 2009. *‘Yo!’ and ‘Lo!’ The pragmatic topography of the space of reasons*. Cambridge: Harvard University Press.
24. Kukla, Rebecca. 2014. “Performative Force, Convention, and Discursive Injustice.” *Hypatia* 29 (2): 440–457.
25. Kukla, Quill R. 2020. “Philosophy, Comedy, and the Need for Good Material.” In *Philosophy by Women*, edited by Elly Vintiadis, 7. Routledge.
26. O’Neill, Eileen. 1998. “HISTORY OF PHILOSOPHY: Disappearing Ink: Early Modern Women Philosophers and Their Fate in History.” In *Philosophy in a Feminist Voice: Critiques and Reconstructions*, edited by Janet A. Kourany, 17-62. Princeton: Princeton University Press.
27. Manne, Kate. 2020. *Entitled: How Male Privilege Hurts Women*. Crown.
28. Murphy, Sarah. 2018. *BPA/SWIP Good Practice Scheme: Impact Report*. (open access)
29. Pang-White, Ann A. 2022. “Introduction: Asian Traditions, Global Contexts: Philosophy, Women, and Gender in the 21st Century.” *Journal of Chinese Philosophy* 49 (1): 5-8.
30. Paxton, Molly, Carrie Fidgor, and Valerie Tiberius. 2012. “Quantifying the Gender Gap: An Empirical Study of the Underrepresentation of Women in Philosophy.” *Hypatia* 27 (4): 949-957.
31. Saul, Jennifer. 2013. “Implicit Bias, Stereotype Threat, and Women in Philosophy.” In *Women in Philosophy: What needs to Change*, edited by Fiona Jenkins and Katrina Hutchinson, 39-61. Oxford University Press.
32. Sean, Allen-Hermanson. 2017. “Leaky Pipeline Myths: In Search of Gender Effects on the Job Market and Early Career Publishing in Philosophy.” *Frontiers in Psychology* 8.
33. Schouten, Gina. 2015. “The Stereotype Threat Hypothesis: An Assessment from the Philosopher’s Armchair, for the Philosopher’s Classroom.” *Hypatia* 30 (2): 450-466.
34. Steele C, M, and J Arson. 1995. “Stereotype threat and the intellectual test performance of African Americans.” *J Pers Soc Psychol.* 69 (5): 797-811.
35. Steele, Claude. 2010. *Whistling Vivaldi: And Other Clues to How Stereotypes Affect Us*. New York: W. W. Norton.
36. Rini, Adriane. 2013. “Models and Values: Why did New Zealand philosophy departments stop hiring women philosophers?” In *Women in Philosophy*, edited by Fiona Jenkins and Katrina Hutchison, 127-143. Oxford University Press.

37. Riach, Peter A., and Judith Rich. "Field experiments of discrimination in the market place." *The economic journal* 112, no. 483 (2002): F480-F518.
38. Xin, Jiang, Yaoxue Zhang, Yan Tang, and Yuan Yang. 2019. "Brain Differences Between Men and Women: Evidence From Deep Learning." <https://www.frontiersin.org/articles/10.3389/fnins.2019.00185/full>.
39. 2021. Zippia The Career Expert. <https://www.zippia.com/philosophy-professor-jobs/demographics/>.
40. 2021. Zippia The Career Expert. <https://www.zippia.com/science-professor-jobs/demographics/>
41. 2021. Zippia The Career Expert. <https://www.zippia.com/humanities-professor-jobs/demographics/>
42. n.d. Institute on gender equality and Women's history. <https://institute-genderequality.org/news-publications/feminism/feminism-18th-century-and-beyond/#:~:text=In%20the%20eighteenth%20century%2C%20enlightened,equality%2C%20originated%20in%20this%20century.>

**Abstract:**

*"Can you name the ten philosophers?" is one of the simplest questions for a philosophy student. Ironically, all it takes to make this question difficult is the addition of one word-women. Even though Elena Cornaro Piscopia received her doctorate in philosophy from the University of Padua in Italy in 1678, 300 years ago (Kalnickō 2021), we continue to categorize "woman philosopher" and "Asian philosopher who specialized in metaphysics," implying that these people are extraordinary. In this article, we questioned whether it was necessary to distinguish between men and women in this "modern, civilized democratic society." To respond to this question, we examined the academic setting in philosophy and considered how gender-related issues are reflected.*